



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 01 дүгээр сарын 23 өдөр

Дугаар 08

Хэрлэн сум

VIII ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 08 дугаар хуралдаан 2021 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 15:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 96,1 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Аймгийн төвд үйл ажиллагаа явуулж байгаа спорт заал, бялдаржуулах төвийн үйл ажиллагааг нээх талаар хэлэлцэх,

Эрүүл мэндийн газар

2.Аймгийн Онцгой комиссын 2021 оны “Эмнэлгийн болон хувийн бариа заслын үйлчилгээг зохицуулах тухай” тогтоолыг дахин хэлэлцэх,

Эрүүл мэндийн газар

3.Улаанбаатар хотоос Дорнод аймгийн иргэдийг татан авахад Хэрлэн сумын багуудыг хариуцан ажилласан талаар танилцуулах,

Онцгой комиссын гишүүд

4.Сүүн бүтээгдэхүүн боловсруулах сургалтад оролцогчдод Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас амны хаалт 50 ширхэг, гар ариутгагч 6 ширхэгийг шийдвэрлүүлэх талаар хэлэлцэх,

Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын орлогч дарга Ч.Ганбат

М.Бадамсүрэн
Д.Баттулга

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д.Мөнхтуяа,

аж, ахуйн нэгж байгууллагын удирдлагуудад:

1.1. Дорнод дээд сургууль, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, Политехник коллеж, Хүний хөгжлийн ордон, Биеийн тамир спортын газрын спорт заалыг халдвар хамгааллын дэглэмийг сахин 10:00-22:00 цагийн хооронд 16-аас дээш насны, 20-оос илүүгүй хүнд үйлчлэх, халуун үзэж бүртгэл хийх, хоёр тоглолтын хооронд 30 минутын хугацаатай байх, тоглолтын цагийн бүртгэл хийх, ээлж солилцох бүрт заал, бөмбөгт халдваргүйтгэл хийж үйл ажиллагааг эхлүүлэхийг,

1.2. Хэрлэн суманд үйл ажиллагаа явуулж байгаа Өргөн, Castle бялдаржуулах төвүүдэд халдвар хамгааллын дэглэмийг сахин 16-аас дээш насны, нэг ээлжинд 10-аас илүүгүй хүнд үйлчлэх, бүртгэл хяналт хийх, халуун үзэх, 2 цаг тутамд заалыг агааржуулах, тоног төхөөрөмжид халдваргүйтгэлийг хийж үйл ажиллагаа эхлүүлэхийг,

1.3. Үйл ажиллагаа эхэлсэн спорт заал, бялдаржуулах төвүүд нь халдвар хамгааллын дэглэм зөрчсөн тохиолдолд аймгийн Онцгой комиссын хурлын шийдвэргүйгээр үйл ажиллагааг шууд зогсоох арга хэмжээ авч байхыг,

Хоёр. Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д.Мөнхтуяа нарт

2.1. Аймгийн Онцгой комиссын 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн “Эмнэлгийн болон хувийн бариа заслын үйлчилгээг зохицуулах тухай” 04 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцохыг,

2.2. Хэрлэн суманд үйл ажиллагаа явуулж байгаа бясалгалын төвүүдийг халдвар хамгааллын дэглэмийг сахиулж үйл ажиллагаа эхлүүлэхийг,



Гурав. Аймгийн Онцгой комиссын гишүүд,

Шуурхай штабын гишүүдэд:

3.1. Улаанбаатар хотоос Дорнод аймагт татан авалтаар ирсэн иргэдтэй төв штабын тандалтын багаас өдөрт нэг удаа утсаар холбогдож хяналт тавьж ажиллахыг,

3.2. Ар гэрийнхэн нь хүлээж авахгүй, олон айлын дунд нэг ариун цэврийн байгууламжтай иргэдийг Эрүүл мэндийн газрын Зооноз судлалын төвд тусгаарлахыг,

3.3. Дорнод аймгаас Улаанбаатар хот руу зорчих хот хоорондын тээврийн автобусаар Улаанбаатар хотод байнга оршин суудаг, хүндэтгэн үзэх шалтгаантай иргэдийг явуулж байхыг,

/  М.Бадамсүрэн
/  Д.Баттулга

Дөрөв.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга,
Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

4.1.Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр байгуулах сургалтад оролцогчдод Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас амны хаалт 50 ширхэг, гар ариутгагч /санитол/ 6 ширхэгийг олгохыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН
ДАРГА М.БАДАМСҮРЭН



АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА, ДЭД ХУРАНДАА Д.БАТТУЛГА

A handwritten signature in black ink, likely belonging to D. Battulga, written below the text of the official.